



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗАР**

Тэмүүжин 01, Сариг баг, Хэрлэн сум,

Чингис хот, Хэнтий аймаг, 23119

Утас/Факс: 70-56-21-34

Цахим шуудан: hen.ndaatgal10001@gmail.com

2025. 06. 12

№

02/201

танай

2025. 05.20

ны №

2/1114

-Т


**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАРТ**

Тус газрын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайдтай байгуулсан хамтран ажиллах
гэрээний биелэлтийг хүргүүлэв.

Хавсралт: 4 хуудастай.

ДАРГА

Н.НЯМХАТАН



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР 2025 ОНЫ ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ

2025.06.05.

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			Хүрсэн түвшин буюу хэрэгжилт / хүрээгүй бол тайлбар /
		2025 оны төсөв	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	
3.3. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Ахмад настны тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.					
3.3.1. Нийгмийн даатгалын талаар:					
3.3.1.1.	Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён ажлыг гэгээрүүлэх эрчимжүүлэх малчид, хувиараа эрхлэгчид, нийгмийн хамруулах ажлыг Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран байгуулах;	1,811,953.7	Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тооны өсөлтийн хувь	Улсын хэмжээнд сайн дураар даатгуулагчийн тоо 2024 он-152 800	ААН албан байгууллага, иргэд даатгуулагчид чиглэсэн сургалтын хүрээнд 135 удаагийн сургалтаар 96 нэгжид сургалт уулзалт хийж, 10800 иргэд, даатгуулагчид сургалт, уулзалтад хамрагдуулан ажилласан байна. ААН албан байгууллага, иргэд даатгуулагчид чиглэсэн сургалтын хүрээнд 135 удаагийн сургалтаар 96 нэгжид сургалт уулзалт хийж, 10800 иргэд, даатгуулагчид сургалт, уулзалтад хамрагдуулан ажилласан байна. Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчлэн найруулга/ батлагдан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр хагас жилийн байдлаар 98 удаагийн сургалтаар 6522 иргэд даатгуулагчдад сургалт, мэдээлэл хүргэн ажилласан.Үүнээс: Ажил олгогч, албан байгууллагат-28 удаагийн сургалтаар 2528 иргэд хамруулсан. Баг, хороонд 21 удаагийн сургалтаар 832 иргэн хамруулсан.

				Оюутан суралцагчдад зориулсан нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах сургалтыг 5 удаа зохион байгуулж 320-н оюутан суралцагч хамруулсан, Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, иргэд, малчдад чиглэсэн сайн дурын даатгалын хамрагдахыг нэмэгдүүлэх сургалтыг 44 удаа зохион байгуулж 2836 иргэн хамруулсан байна.
				Хэрэгжилтийн хувь : 100 %
3.3.1.2.	Нийгмийн даатгалын үйлчилгээг аймаг, дүүргийн иргэдэд шуурхай хүргэх зорилгоор нийгмийн даатгалын цахимжуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	Цахим хэлбэрт шилжүүлсэн тэтгэврийн хувийн хэргийн эзлэх хувь	-	Тус газрын 2025 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авч буй 14094 тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэрэг, материалыг цахимжуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2025 оны 05 сарын 31-ний байдлаар цахимжуулах ажил 60 хувьтай явагдаж байна.
3.3.1.3.	Даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд ажил олгогч хуулиар хүлээсэн эрх, үүргээ биелүүлж, нийгмийн даатгалын нийгмийн шимтгэлийн өр үүсгэхгүй байх, өр үүссэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг шуурхай барагдуулахад Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;	Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо	Улсын хэмжээнд өртэй төсөвт байгууллагын тоо -848	Хэрэгжилтийн хувь : 80 % 2025 оны хагас жилийн байдлаар урд оны авлага 1721.1 сая төгрөгөөс 1617.8 сая төгрөг буюу 94 хувийг барагдуулсан болно. Урсгал авлага 2,590.0 сая төгрөгт хүрээд байна. 2025 оны хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 183 ажил олгогчийн 482,3 сая төгрөгийн авлагад дансны хаалт хийж барагдуулаад байна. Мөн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэггүй 3 байгууллагад торгуулийн арга хэмжээ ногдуулж 2 ажил олгогчийн гаргасан зөрчилд алданги тооцсон.

ХӨТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	1,811,953.7			88,75%
----------------------	-------------	--	--	--------

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР